



07/2021

Тархаасан: 2021 оны 7 дугаар сарын 17

**АНУ-ын эдийн засаг** 


АНУ-ын Эдийн засгийн шинжилгээний товчооны мэдээллээр тус улсын ДНБ-ий жилийн өсөлт 2021 оны 1 дүгээр улиралд 6.4 хувь байна.

Улирлын нөлөөллийг арилгасан хэрэглээний үнийн индекс 2021 оны 5 дугаар сард өмнөх сараас 0.6 хувиар өссөн байна.

АНУ-ын экспорт 2021 оны 5 дугаар сард 206.0 тэрбум ам.доллар, импорт 277.3 тэрбум ам.доллар болж, гадаад худалдааны тэнцэл 71.3 тэрбум ам.долларын алдагдалтай гарсан байна. Экспорт өмнөх сараас 1.3 тэрбум ам.доллар, импорт 3.5 тэрбум ам.доллар, алдагдал 2.2 тэрбум ам.доллаароор тус тус нэмэгдсэн байна.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн индекс урьдчилсан гүйцэтгэлээр 2021 оны 5 дугаар сард 99.9 (2017=100) болж, өмнөх оны мөн үеэс 16.3 хувиар, өмнөх сараас 0.9 хувиар өссөн байна.

Улирлын нөлөөллийг арилгаснаар ажилгүйдлийн түвшин 2021 оны 6 дугаар сард 5.9 хувь болж, өмнөх сараас 0.1 пунктээр нэмэгдсэн байна.

**БНХАУ-ын эдийн засаг** 

БНХАУ-ын Үндэсний статистикийн товчооны мэдээллээр тус улсын ДНБ 2021 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 18.3 хувиар өссөн байна.

Хэрэглээний үнийн индекс 2021 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 1.3 хувиар өссөн бол өмнөх сараас 0.2 хувиар буурсан байна.

БНХАУ-ын гадаад худалдааны нийт бараа эргэлт 2021 оны эхний 5 сард 2.2 их наяд ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 38.1 хувиар өссөн байна. Үүнд экспорт 12.4 их наяд ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 40.2 хувиар, импорт 10.3 их наяд ам.долларт хүрч, 35.6 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна. Гадаад худалдааны тэнцэл 2021 оны эхний 5 сард 2.0 тэрбум ам.долларын ашигтай гарчээ.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс 2021 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 8.8 хувиар өсч, өмнөх сараас 1.0 хувиар буурчээ.

Хотын хүн амын ажилгүйдлийн түвшин 2021 оны 5 дугаар сард 5.0 хувь болж, өмнөх сараас 0.1 пунктээр өссөн байна.

**Япон улсын эдийн засаг** 

Япон улсын ДНБ 2021 оны 1 дүгээр улиралд урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх улирлаас 3.9 хувиар буурсан байна.

Хэрэглээний үнийн индекс 2021 оны 5 дугаар сард 101.7 (2015=100) болж, өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар буурч, өмнөх сараас (улирлын нөлөөллийг арилгаснаар) 0.3 хувиар өссөн байна.

Экспорт 2021 оны 5 дугаар сард 6.3 их наяд иен, импорт 6.4 их наяд иен болж, өмнөх оны мөн үеэс экспорт 49.6 хувиар, импорт 27.9 хувиар тус тус өссөн байна. Гадаад худалдааны тэнцэл 2021 оны 5 дугаар сард 189.4 тэрбум иений ашигтай гарсан байна.

Улирлын нөлөөллийг арилгасан аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн индекс 2021 оны 5 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 94.1 (2015=100) болж, өмнөх сараас 5.9 хувиар буурсан байна.

Япон улсын ажилгүй иргэдийн тоо 2021 оны 5 дугаар сард 2 сая хүн болж, өмнөх оны мөн үеэс 60.0 мянган хүнээр нэмэгдсэн байна. Улирлын нөлөөллийг арилгасан ажилгүйдлийн түвшин 3.0 хувь байна.

#### Европын холбооны гишүүн орнуудын эдийн засаг



Европын холбооны Статистикийн газрын мэдээллээр тус холбооны гишүүн улс, орнуудын улирлын нөлөөллийг арилгасан ДНБ 2021 оны 1 дүгээр улиралд өмнөх улирлаас 0.1 хувиар, өмнөх оны мөн үеэс 1.3 хувиар тус тус буурсан байна.

Европын Холбооны гишүүн орнуудын инфляцын жилийн түвшин 2021 оны 5 дугаар сард 2.0 хувь болж, өмнөх сараас 0.4 пунктээр, өмнөх оны мөн үеэс 1.9 пунктээр өссөн байна.

Европын Холбооны гишүүн орнуудын экспорт 2021 оны эхний 4 сард 688.1 тэрбум евро болж, өмнөх оны мөн үеэс 3.9 дахин, импорт 626.6 тэрбум евро болж 3.8 дахин өссөн байна. Гадаад худалдааны тэнцэл 61.4 тэрбум еврогийн ашигтай гарсан байна.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс 2021 оны 5 дугаар сард 109.3 (2015=100) болж, өмнөх оны мөн үеэс 9.6 пунктээр, өмнөх сараас 1.4 пунктээр өсчээ.

Европын Холбооны гишүүн орнуудын ажилгүйдлийн түвшин улирлын нөлөөллийг арилгаснаар 2021 оны 4 дүгээр сард 7.3 хувь болж, өмнөх сарын түвшинд байгаа бол өмнөх оны мөн үеэс 0.6 пунктээр өссөн байна. Харин ажилгүй иргэдийн тоо өмнөх сараас 165 мянгаар, өмнөх оны мөн үеэс 1.6 саяар өсжээ.

#### ОХУ-ын эдийн засаг



ОХУ-ын Эдийн засаг, хөгжлийн яамны тооцоогоор тус улсын ДНБ 2021 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 0.7 хувиар буурсан байна.

Хэрэглээний үнийн индекс 2021 оны 5 дугаар сард өмнөх сараас 0.7 хувиар, өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар өссөн байна.

ОХУ-ын гадаад худалдааны нийт бараа эргэлт 2021 оны эхний 4 сард 219.0 тэрбум ам.долларт болж, өмнөх оны мөн үеэс 16.5 хувиар өссөн байна. Экспорт 128.7 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 12.6 хувиар, импорт 90.5 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 22.8 хувиар тус тус өсжээ. Гадаад худалдааны тэнцэл 2021 оны эхний 4 сард 38.2 тэрбум ам.долларын ашигтай гарчээ.


Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн индекс 2021 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 11.8 хувиар өсөж, өмнөх сараас 2.1 хувиар буурсан байна.

Ажилгүй иргэдийн тоо 2021 оны 5 дугаар сард 3.7 саяд хүрч, ажилгүйдлийн түвшин 4.9 хувь болсон байна.

#### Алт, зэсийн үнэ

Лондонгийн үнэт металлын биржид 1 тонн цэвэр зэсийн үнэ 2021 оны эхний хагас жилийн дунджаар 9094.6 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 3604.8 ам.доллороор нэмэгдсэн байна.

Зураг 1. Лондонгийн үнэт металлын бирж дэх алт, зэсийн үнэ, жил бүрийн эхний хагас жилийн дунджаар




Лондонгийн үнэт металлын биржид 1 унц алтны үнэ 2021 оны эхний хагас жилийн дунджаар 1807.1 ам. доллар болж, өмнөх оны мөн үеэс 160.3 ам. доллароор өссөн байна.

### Газрын тосны үнэ

Нью-Йоркийн худалдааны биржид 1 баррель газрын тосны үнэ 2021 оны эхний хагас жилийн дунджаар 62.0 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 25.1 америк доллароор өссөн байна.

Зураг 3. Нью-Йоркийн худалдааны бирж дэх газрын тосны үнэ, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар дунджаар (ам.доллар)



### Хөрөнгийн биржийн индекс

АНУ-ын Хөрөнгийн биржийн Аж үйлдвэрийн Dow Jones индекс 2021 оны эхний хагас жилийн дунджаар 34 046.2 нэгж болж, өмнөх оны мөн үеэс 8427.8 нэгжээр өссөн байна.

Токиогийн Хөрөнгийн биржийн Nikkei-225 индекс 2021 оны эхний 3 сарын дунджаар 28962.4 нэгж болж, өмнөх оны мөн үеэс 7623.0 нэгжээр өссөн байна.

Лондонгийн Хөрөнгийн биржийн FTSE-100 индекс 2021 оны эхний 3 сарын дунджаар 7011.9 нэгж болж, өмнөх оны мөн үеэс 361.3 нэгжээр өссөн байна.

Хүснэгт 1. Хөрөнгийн биржийн индекс, сараар

	Аж үйлдвэрийн Dow Jones	Nikkei- 225 <sup>2</sup>	FTSE-100 <sup>3</sup>
2017 I	19 908.2	19 194.1	7 211.4
II	20 424.1	19 188.7	7 240.4
III	20 823.1	19 340.2	7 359.5
IV	20 684.7	18 736.4	7 263.6
V	20 936.8	19 726.8	7 422.7
VI	21 331.4	20 045.4	7 455.8
<b>2017 I-VI</b>	<b>20 684.7</b>	<b>19 371.9</b>	<b>7 325.6</b>
VII	21 581.3	20 038.7	7 395.9
VIII	21 890.8	19 601.4	7 409.2
IX	22 173.4	19 912.9	7 334.7
X	23 020.0	21 262.5	7 508.9
XI	23 557.9	22 525.8	7 418.5
XII	24 545.4	22 769.9	7 481.7
I-XII	21 739.7	20 195.2	7 375.2
2018 I	25 804.0	23 712.2	7 695.7
II	24 981.5	21 991.7	7 255.9
III	24 582.2	21 395.5	7 090.1
IV	24 582.2	21 868.8	7 288.2
V	24 572.5	22 590.1	7 690.2
VI	24 790.1	22 562.9	7 656.9
<b>2018 I-VI</b>	<b>24 885.4</b>	<b>22 353.5</b>	<b>7 446.2</b>
VII	24 978.2	22 322.2	7 651.1
VIII	25 630.0	22 494.1	7 605.6
IX	26 232.7	23 159.3	7 385.9
X	25 609.3	22 690.8	7 137.0
XI	25 258.7	21 967.9	7 040.8
XII	23 832.1	21 402.7	6 790.9
I-XII	25 056.8	22 347.0	7 364.2
2019 I	24 157.8	20 460.5	7 558.0
II	25 605.5	21 123.6	7 313.5
III	25 722.6	21 414.9	5 741.9
IV	26 401.6	21 964.9	6 871.1
V	25 744.8	21 218.4	6 861.6
VI	26 160.1	21 060.2	7 147.3
<b>2019 I-VI</b>	<b>25 632.1</b>	<b>21 207.1</b>	<b>6 915.6</b>
VII	27 089.2	21 593.7	7 204.6
VIII	26 057.7	20 629.7	7 434.2
IX	26 900.2	21 585.5	7 275.3
X	26 736.8	22 197.5	7 359.3
XI	27 797.1	23 278.1	7 549.3
XII	28 167.0	23 660.4	7 203.5

I-XII	26 378.4	21 682.3	7 320.0
2020 I	28 880.0	23 642.9	7 221.3
II	28 519.7	23 180.4	7 348.3
III	22 671.7	18 974.0	7 403.7
IV	23 293.9	19 208.4	5 729.4
V	24 271.0	20 543.3	5 956.3
VI	26 074.1	22 486.9	6 244.6
<b>2020 I-VI</b>	<b>25 618.4</b>	<b>21 339.3</b>	<b>6 650.6</b>
VII	26 260.6	22 529.5	6 167.4
VIII	27 720.8	22 901.5	6 073.8
IX	23 272.2	23 306.9	5 933.0
X	23 604.9	23 451.4	5 851.5
XI	22 044.8	25 384.9	6 222.5
XII	20 477.0	26 772.0	6 518.9
2021 I	32 345.6	28 189.1	6 698.5
II	31 283.9	29 458.8	6 583.6
III	30 821.4	29 315.3	6 713.6
IV	33 691.7	29 426.8	6 914.2
V	34 200.3	28 517.1	7 024.1
VI	34 246.8	28 943.2	7 097.4
<b>2021 I-VI</b>	<b>34 046.2</b>	<b>28 962.4</b>	<b>7 011.9</b>

Мэдээлэл авах линкүүд:

1. <http://www.bea.gov/>
2. <http://www.stats.bls.gov>
3. <http://www.census.gov>
4. <http://www.federalreserve.gov>
5. <http://www.bls.gov>
6. <http://www.stats.gov.cn>
7. <https://www.esri.cao.go.jp>
8. <http://www.stat.go.jp>
9. <https://www.customs.go.jp>
10. <https://www.meti.go.jp>
11. <https://ec.europa.eu/eurostat>
12. <https://www.economy.gov.ru>
13. <https://rosstat.gov.ru>
14. <http://www.lme.com>
15. <http://www.lbma.org.uk/>
16. <http://www.finance.yahoo.com>

Тайлбар: \*Улирлын нөлөөллийг тооцоогүй.

Үндэсний тооцоо, шинжилгээ судалгааны  
газрын дарга А.Дэмбэрэл  
Утас : (976-51)-329271

Үндэсний тооцоо, шинжилгээ судалгааны  
газрын статистикч С.Дарьмаа  
Утас : (976-51)-262903